

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Премиумкөүл корпораци” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011359044, Регистрийн дугаар: 5615631, Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV - 016975
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, 15-р хороо, Жаргалант, 60-63, Утас: 95099890
Төслийн байршил:	Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах ба Улаанбаатар хотоос 810км-т, Баруун-Урт хотоос зүүн урагш 80км, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт-Зүүн хатавчийн хилийн боомтоос 180км-т оршино.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дахь Төхөмийн MV – 016975 дугаар бүхий ашиглалтын талбайд нүүрсний нөөцийг ашиглана. Талбайн нийт хэмжээ 537.95 га болно.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	114 ⁰ 15' 0.02''	46 ⁰ 33' 51.76''
2	114 ⁰ 13' 22.39''	46 ⁰ 33' 51.56''
3	114 ⁰ 13' 22.39	46 ⁰ 35' 1.76''
4	114 ⁰ 15' 32.4''	46 ⁰ 35' 1.76''
5	114 ⁰ 15' 32.4''	46 ⁰ 34' 20.22''
6	114 ⁰ 15' 0.02''	46 ⁰ 34' 20.22''

Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн өнөөгийн байдал



1.2 Ордын нөөц хүчин чадал, календарь төлөвлөлт

Төхөм нэртэй MV-016975 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын ХХ-06-04 тоот дүгнэлтийн үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2011 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 162 дугаар тушаалаар нийт А зэргээр 65,848.3 мян.тн, В зэргээр 72,265.6 мян.тн нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. ТЭЗҮ нь ордын баттай болон бодитой /А+В/ нөөцөд тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд хаягдал, бохирдолтыг тооцон үйлдвэрлэлийн нөөцийг тооцоолоход 136324.58 мян.тн нүүрс олборлохоор байна.

Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 1.63% (2.25 сая.тн), бохирдолтыг 0.14% (0.19 саян.тн) тус тус авч тооцсон ба ордыг 93 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 54.4 сая.м³ хөрс хуулж, магадалсан В үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 136.05 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 1.5 сая.тн бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 0.4 м³/тн.

Уурхай дөрөв дэх жилээсээ хүчин чадлаа бүрэн эзэмших ба нийт А+В нөөцийг бүрэн ашиглахад 93 жилийн хугацаанд ажиллахаар байгаа бөгөөд цаашид ашиглалтын үеийн хайгуулаар боломжтой С зэрэглэлээр нөөцийн зэрэглэлийг ахиулах, нөөцийн хэмжээ өсөх зэргээр уурхайн ашиглалтын хугацаа нэмэгдэхээр байна.

Хүснэгт 2. Уурхайн жил бүрийн уулын ажлын төлөвлөлт

Ашиглалтын жилүүд	Нийт уулын цулаар, м ³	Жилд хуулах хөрсний хэмжээ, м ³	Жилд олборлох нүүрсний хэмжээ, тн	Хөрс хуулалтын дундаж коэффициент м ³ /тн
1	884615.4	500000	500000	1.0
2	1215384.6	600000	800000	0.8
3	1663076.9	740000	1200000	0.6
4	1893846.2	740000	1500000	0.5
5	1786846.2	633000	1500000	0.4
6	1553846,2	400000	1500000	0.3
7	1553846,2	400000	1500000	0.3
8	1553846,2	400000	1500000	0.3
9	1553846,2	400000	1500000	0.3
10	1553846,2	400000	1500000	0.3
Нийт	15213000	5213000	13000000.0	0.4

Нийт төслийн эхний 10 жилийн хугацаанд 5.2 сая.м³ хөрс хуулж 13.0 сая.тн нүүрс олборлох ба 15.2 сая.м³ уулын цулын ажил хийгдэхээр тооцоологдож байна. Хөрс хуулалтын коэффициент дунджаар 0.4 м³/тн байгаа нь уулын ажил явуулахад хүндрэл багатай нэгэн жилд ажиллахад чухал нөлөөтэй.

1.3 Уурхайн ажлын горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцон уурхай нь 300 хоног ажиллана.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хоног
1	Жилийн хоногийн тоо	365
2	Баяр ёслолын өдрүүд	9
3	Засварт зогсох өдөр	35
4	Цаг агаарын саатал	10
5	Улирал хагас жилийн сул зогсолт	9
6	Бусад	2
7	Уурхайн жилд ажиллах хоног	300

Уулын ажил явагдаж буй хөрс хуулалт, олборлолт, ус таталт гэх мэт технологийн ажилчид 2 ээлжээр 12 цаг ажиллана. Харин удирдлага, засвар үйлчилгээ, зам тавих, засах зэрэг технологийн бус ажилчид өдөрт 8 цагаар ажлын 5 өдөр ажиллана.

1.4 Дэд бүтэц

Уурхайн засвар, техникийн үйлчилгээ: Тус уурхайн засвар, техникийн үйлчилгээний дэд бүтэц нь уулын механик тоног төхөөрөмж, автотээврийн болон технологийн комплексийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийхийн зэрэгцээ засвар ашиглалтын хэрэгцээний төрөл бүрийн материал, сэлбэг хэрэгсэл, түлш, тос зэргийг хүлээн авч хадгалах, тавьж олгох зориулалттайгаар төсөлд тусгагдлаа. Засвар, техникийн үйлчилгээний ажлын зохион байгуулалтын энэхүү үндэслэл нь уурхайн механик тоног төхөөрөмж, тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварын систем юм.

Тус уурхайн засварын газар нь уул-тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн урсгал засвар, техникийн үйлчилгээг гүйцэтгэхдээ зарим хялбар эд ангийг шинээр хийх, сэргээн засварлах болон бэлэн эд анги хэрэглэн агрегат зангилгааны аргаар хийнэ.

Сэлбэг материалын агуулах: уурхай дээр тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг хэрэгсэл, бараа материалын агуулах, мөн хүнсний агуулах барихаар тусгав. Агуулахууд үйлдвэрлэлийн талбайд байрлана.

Уурхайчдын тосгон: Уурхайд захиргааны байр, ажилчдын орон сууц, хоолны газар байна.

Зураг 3. Ажилчдын байр



Зураг 4. Хоолны газар



Бараа материалын агуулах: Уурхайд машин техник, тоног төхөөрөмжийн шаардлагатай сэлбэг хэрэгсэл, материалуудыг агуулах бараа материалын агуулах байна. Мөн ажиллагсадын хүнсний материалын агуулах байна.

Дизель түлш, шатах материалын агуулах: Уурхайд жилд дизелийн түлш 6,370 тн, шатах тослох материал 21.8тн, тус тус хэрэглэнэ. Түлш зөөх зориулалтын машин 1ш-ийг, түлш хадгалах зориулалтаар 50тн-ын багтаамжтай ган сав 1ш-ийг, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төсөлд тусгав. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Усан хангамж: Уурхайн ажилчдын ундны усны хэрэгцээг гүний худгаас хангана. Гүний худаг нь N465747278, E114222815 солбицолд, цооногийн гүн 100 метрт байхаар тооцоолсон.

Цахилгаан хангамж: 220кВт чадалтай дизель станц 1ш- ийг үйлдвэрлэлийн талбайд, 60 кВт-ын чадалтай дизель станц 1ш – ийг тосгонд байрлуулж эрчим хүчээр хангахаар төсөлд тусгав. Уурхайн цахилгаан хэрэглэгчид нь гүний ус зайлуулах насос, уурхай болон овоолгын гэрэлтүүлэг, уурхайн ил ус зайлуулах насос, нүүрсний агуулах, авто засварын газар, захиргаа үйлчилгээний газар, уурхайчдын тосгон, шатах тослох материалын агуулах, уурын зуух зэрэг байна.

Зураг 5. Дизель генератор



Цэвэрлэх байгууламж

Нийт 20-50 хүний хүчин чадлаар бохир усыг цэвэршүүлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжтай.

Зураг 6. Цэвэрлэх байгууламж



1. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн байршилтай холбоотой: физик газарзүйн мужлалаар тус талбай нь Монгол орны Зүүн бүсийн говь хээрийн бүсэд хамаарагдах ба газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр ухаа гүвээг тэгш талын өндөрлөг хэв шинжид багтана. Энд газрын гадаргуугийн дундаж өндөржилт далайн түвшнээс дээш 978-1155м байх бөгөөд харьцангуй өндөржилт 50-150м хооронд хэлбэлзэнэ. Дээрх бэсрэг уулсын орой нь бөмбөгөр хэлбэртэй хажуу нь элэгдэж, хадан гарш, мөргөцөг үүсгэх нь элбэг. Өндөрлөгүүдийн хажуу бэлээр хадан гарш муутай, тэгш толгод гадаргад өндөрлөг болон үргэлжилдэг.

Гадаргуугийн дээрх нөхцөлд элэгдлийн үйл ажиллагаа сул явагдаж, усан сүлжээ муу хөгжсөн, бэсрэг уулсаас эх авсан хуурай сайрууд нь хэрчигдэл багатай, хэдэн зуун метрээс хэдэн мянган км үргэлжилж, хоолой хөндийн тэгш гадаргад шилжинэ. Хуурай гол сайрын өргөн хэдэн арван метр, заримдаа 100м хүрэх ба голын дэнж муу хөгжсөн.

Зураг 7. Лицензийн талбайн сансрын зураг



Ус зүй: Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд багтана. Гадаргын усны ихээхэн хэсэг нь 30-100мг/л эрдэсжилттэй учир зөөлөн усанд тооцогдоно. Талбайн урд хэсэгт давстай олон тооны жижиг нуур цөөрөм тохиолддог (Цагаан нуур, Давст нуур). Талбайн хэмжээнд тогтмол урсгал усгүй.

Тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч нуур, тойром, худгийн усны түвшин өөрчлөгдөнө. Цас их унаж хайлах, үргэлжилсэн ширүүн бороотой үед хотос хонхор газар, нуурууд нь устай болох ба хуурай сайрууд нь гол болж ус урсах, бороо хур татрахад усгүй болно. Хуртай үед үүссэн нуур, тойром хэдэн долоо хоногоос хэдэн сар устай байж хүн, мал ундаална. Булаг шандууд хэдэн метр урсаад элс, хайрга доогуур шургаж орно. Хүн малын ундаанд зөвхөн худгийн усыг хэрэглэх бөгөөд худгуудыг хуурай сайр, хөндий, нуурын зах хэсгийг бараадуулан гаргасан байдаг. Худгийн усны гүний түвшин 1-2 м, зарим тохиолдолд 5-7м.

Төхөмийн ордын орчимд тархсан газар доорх усны химийн найрлага нь хлор сульфатын ангийн, натри-калийн бүлгийн ус зонхилох бөгөөд усны эрдэсжилтийн хэмжээ 3.1-3.5г/л, ерөнхий хатуулаг 52.7-57.62мг/экв, рН 15.6-16.9 байна. Шинжилгээний дүнгээс үзэхэд эрдэсжилт ихтэй давслаг, хатуулаг их илэрч байгаа нь бетонон эдлэлд тохиромж муутай, унд ахуйн хэрэгцээнд тохирохгүй. Баянхошуу худгийн усны химийн шинжилгээнээс харахад гидрокарбонат-сульфит-хлорын найрлагатай. Эрдэсжилт нь 0.5г/л байгаа боловч хатуулаг нилээд ихтэй, исэлдэх чанар, идэмхий нүүрс хүчлийн хий зэрэг зарим үзүүлэлтүүд чанарын шаардлага хангахгүй байна.

Уур амьсгал: Цаг агаарын хувьд хамгийн хүйтэн нь 1 сард -30°C хүрдэг. Хамгийн халуун нь зуны улиралд буюу 7сард $+30^{\circ}\text{C}$ $+35^{\circ}\text{C}$ хүрдэг байна. Агаарын чийгшилт дунджаар 40-50%. Ус чийг багатай тул манан будан ажиглагдахгүй. Хур тунадасны хэмжээ маш бага. Зуны улиралд түр зуурын бороо ордог. Өвөлдөө цас маш бага унадаг. Зарим жилүүдэд 14см хүртэл цасан бүрхүүл тогтдог гэсэн мэдээ байдаг. Төхөмийн талбай нь эх газрын эрс тэс уур амьсгалтай жилийн агаарын температурын өөрчлөлт их халуун хүйтний хэлбэлзлийн хязгаар жилийн 4 улиралд харилцан адилгүй байдаг.

Өвлийн улиралд цасан бүрхүүл жигд биш, алаг цоог тархана. Цасан бүрхүүлийн зузаан хойд хэсэгт дунджаар 6- 8см, урд хэсэгт дунджаар 3-4см байна. Улирлын хөлдөлт газар сайгүй харилцан адилгүй гүнтэйгээр явагдах ба талбайн хойд хэсгээр 0.8м, урд хэсгээр 0.5м орчим байдаг. Салхины хоногийн хэлбэлзэл ихтэй. Жилийн дунджаар авч үзвэл салхигүй өдрийн тоо 20-25 хоног байдаг. Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд жилийн салхины дундаж хурд 4-9м/с байна. Жилд дунджаар 32-39 хоног 15м/с хүртэл хүчтэй цасан ба шороон шуурга шуурдаг.

Хөрсөн бүрхэвч: Говь хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хөрс үүсэхэд хур тунадас, салхи ихээхэн үүрэгтэй. Салхи нь хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж ууршилтыг ихэсгэснээр хөрс хуурайшихад нөлөөлөөд зогсохгүй өнгөн хэсгийг нь хийсгэж нүүлгэн, хөрс эвдэхэд ихээхэн нөлөөтэй. Хур бороо элбэг үед ургамлын бүрхэвч сайжирч хөрсний эвдрэл үүсэх нөхцлийн багасгана. Тэгш өндөрлөг газруудад бор саарал хөрс зонхилж, мараалаг борзон хайрга, чулуун хуягаар зарим газраа бүрхэгдэнэ. Хонхор хотгор газруудаар хужир тойром, мараалаг хөрс элбэг тархана. Зарим газруудын ар хормой бэлээр элсэрхэг хөрс зонхилно.

Ургамлан нөмрөг: Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвст, монгол өвст-хазаар өвс говирхог хээр боловч монгол өвст таанат, монгол өвст бударганат хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана, хөмөл, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг. Ургамал ерөнхийдөө сийрэг боловч тачирхан, тэжээллэг чанар сайтай учир бэлчээрийн багагүй ач холбогдолтой. Сүүлийн жилүүдэд хур тунадас бага орж, зуны цагт хуурайшин халснаас болж ургамлын гарц муудаж байна.

Амьтны аймаг: Энд туурайтнаас хамгийн их тархсан нь цагаан зээр бөгөөд намартаа нүүдэллэн ирдэг. Жигүүртнээс сар, элээ, хэрээ, харцага, тогоруу, ногтруу, шаазгай, хулан жороо, шар шувуу, өвөөлж, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчдээс шар сүүлт, алаг даага, тарвага (маш бага), махчин амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, шавж идэштнээс зараа зэрэг орно.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Судалгааны талбайд хүн амын суурьшил дунд зэрэг, нэг кв.км талбайд 0.1-5хүн суудаг. Халх ястан, мал аж ахуй эрхэлж, нүүдлийн байдлаар амьдардаг. Өвлийн болон отор нүүдлийн үед бусад аймаг сумдын малчид ирж нутагладаг байна. Суманд багийн төвүүд байдаг боловч багийн төвийг тогтмол ажиллуулдаггүй тул байшин барилгыг хувийн мэдэлд шилжүүлэн нурааж, эвдсэн байна.

Хүн амын гол хөдөлмөр нь мал аж ахуй (хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ). Захиргаа, эмнэлэг, сургууль (8 жилийн), холбоо зэрэг улсын төсвийн байгууллага ажиллахаас гадна хувийн хэвшлийн компаниуд худалдаа үйлчилгээ эрхэлдэг. Аймаг, сумын хооронд автотээвэр, холбоо харилцаа хөгжсөн ба шороон замтай. Тээвэр харьцангуй сайн хөгжиж буй нутаг юм. Өндөр хүчдэлийн шугам холбогдсон. Сумын төвүүдэд үндэсний болон гадаадын телевизийн нэвтрүүлэг үзэх боломжтой, үүрэн телефоны сүлжээ орсон. Ийнхүү Төхөмийн талбай нь уул уурхайн үйлдвэрлэл эрхлэхэд газарзүйн тааламжтай нөхцөлтэй бүсэд оршино. Дэд бүтэц сайн хөгжөөгүй, хүн амын нягтрал сийрэг хатиган халхчууд зонхилно. Орон нутгийн иргэд мал аж ахуй эрхлэн амьдардаг. Энэ сумын төв нь цахилгаан эрчим хүчний шугаманд ходбогдоогүй, эмнэлэг, үүрэн телефоны станц, 9 жилийн дунд сургууль, ШТС, дэлгүүр зэрэг газруудтай. Талбай нь бусад сум багтай шороон замаар холбогддог. Ордын талбайгаас баруун-хойш 100км зайд Талбулагийн нүүрсний уурхай, зүүн-хойш 45км-т Хөөтийн нүүрсний орд оршино.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь тухайн жилд хэрэгжүүлэх уурхайн олборлолтын үед байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг бууруулах арга зам, хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эдгээр арга хэмжээ оновчтой, үр дүнтэй байгаа эсэхийг хянах, илүү бодитой арга хэмжээ төлөвлөхөд чухал ач холбогдол бүхий орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахад оршино.

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	2024 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	төг	1,200,000
2	Нөхөн сэргээлт, хаалтын ажлын зардал	төг	750,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг	10,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	төг	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төг	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төг	Дотоод төсөв
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	төг	2,400,000
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	төг	1,440,000
9	БОМТ -г орон нутагт тайлагнах	төг	-
10	Тухайн жилийн байгуул орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	төг	-
	Дүн	төг	15,790,000

“Премиумкөүл корпораци” ХХК-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний “Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тухай” заалтанд байгаа байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой зардалд 15,790,000 төгрөгийг төсөвлөв. 2023 оны 10-р сарын 03-ны өдөр БОАЖЯ-ны дансанд 3,000,000 / гурван сая / төгрөгийг байршуулсан ба тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах үедээ 4,895,000 төгрөгийг БОАЖЯ-ны Төрийн сангийн дансанд байршуулна.

2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ							
1	Хөрсний үржил шим алдагдах	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Үйл ажиллагааны турш	ҮАЗ		2024 он	Хөрс хамгаалах Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2		Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хориглох, тогтсон маршрутаар зорчуулах.	Уурхай хэмжээнд	ҮАЗ		2024 он	Газрын тухай хуулийн 50.1.1
3		Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах.	Төсөл хэрэгжих талбайд	ҮАЗ		2024 он	MNS5914:2008, “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”
4	Уурхайн үйл ажиллагаа улмаас газрын гадарга эвдэрч хөрсөн бүрхэвч устах	Уурхайн тосгоны тоосжилтын бууруулж, мод, бут тарих, зүлэгжүүлэх ажлыг эхлүүлэх.	Уурхайн хэмжээнд	НСЗ		2024 он	MNS5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
6	Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдал гэх мэт аюултай хог хаягдлын бүртгэл гаргаж ажиллах.	Үйл ажиллагааны турш	-		2024 он	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон
7		Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлуулах менежментийг бий болгох.	Үйл ажиллагааны турш	ҮАЗ		2024 он	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
8		Карьерт хүн, мал, ан амьтан унахаас сэргийлэх арга хэмжээ авах,	Үйл ажиллагааны турш	500,0		2024 он	биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
Нийт = 500,000							
ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС							
1	Унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар усыг их хэмжээгээр ашигласнаар усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх, усны тоолуур бүхий төхөөрөмж суулгах	Уурхайн ажилчид	200,0	200,0	Төсөл хэрэгжих хугацаанд	Усны тухай хууль: Зүйл 24-1.1, 1.2; Зүйл 30; Зүйл 31-1, 2, 3, 4, 5, 6, 8; Зүйл 33-1, 2, 3; Зүйл 34-1, 2; Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОНБНУ, Компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө
		Унд ахуйн усны шинжилгээг хийлгэх	Унд ахуйн усанд	ОХШХ	ОХШХ		
4		Уурхай дотор болон уурхайн ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх (урьдчилан сэргийлэх арга хэмжээнд)	Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй нийт талбайн хэмжээнд	--*--	--*--	Төсөл хэрэгжих хугацаанд	
5		Тоосжилтыг дарах зорилгоор автозам, уурхайн карьерын мөргөцөг, шинэ овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр	Уурхайн үйл ажиллагаанд	500.0	500.0	Ашиглалтын 1-р жилд цаашид төсөл хэрэгжих хугацаанд тогтмол	
		Дүн			700,0		
НИЙТ = 1,200,000							

3.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын ашиглалтын явцад техникийн нөхөн сэргээлтийн ажил нь төслийн 6,7 дэх жилээс эхлэх бөгөөд эхний 5 жилд ажилчидын хотхон орчмын талбайд мод, үр тариа суулгаж ногоон байгууламж бий болгоно.

Хүснэгт 4. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал, ажлын хэмжээ

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Ашиглагдах техник, тайлбар	Нэгж ажлын зардал, төг	Нийт зардал, төг
I	Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал					
1.1	Бүрхэвч ургамал тарих	га	28.7	Экскаватор	750,000	
1.2	Олон наст ургамлын үр тарьж суулгах	га	14.3	Гэрээт компани		
1.3	Усалгаа, арчилгаа, тордолт хийх	га	2.0	Хүн, усалгааны машин		
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН = 750,000						

3.3 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

3.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллана.

3.5 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд үндсэн 3 хүртэлх болзошгүй осол сөрөг нөлөөллийн хүрээнд 9 хүртэлх урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээний ажлыг төлөвлөж ажиллахаар байна.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах.	Дотоод журам	-
		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах.	ҮАЗ	Жилд 1 удаа
		Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байршуулах.	ҮАЗ	Жил бүр тогтмол
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	ҮАЗ	Жил бүр тогтмол
2	Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Жил бүр тогтмол
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	ҮАЗ	Жил бүр тогтмол
		Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины кабин, ажлын байрт байршуулах.	ҮАЗ	Жил бүр тогтмол
		Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах.	ҮАЗ	Жил бүр тогтмол
3	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах - Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	ҮАЗ	Жил бүр тогтмол
НИЙТ				

3.6 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төхөмийн нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас гарч буй хатуу, шингэн, төлөв байдлын бүх төрлийн хог хаягдлуудын зохицуулалтад, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартууд, байгууллагын дотоод журмыг мөрдөн ажиллана.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авах.	ҮАТ	Үйл ажиллагааны зардалд	2,400,000	2024 он	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
2		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байршуулах.	ҮАТ	Үйл ажиллагааны зардалд			
3		Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	ҮАТ	Гэрээний дүнгээр			
4		Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх.	ҮАТ				
5		Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх буулах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах цэвэр эрүүл орчинд ажиллах амьрдах орчныг бий болгоход орон нутагтай хамтран ажиллах.	ҮАТ				
7	Аюултай хог хаягдал	Санамсар болгоомжгүйгээр ШТМ болон бусад аюултай шингэн хог хаягдал хөрсөнд ил задгай асгарсан тохиолдолд даруй тухайн хөрсийг хуулан авч саармагжуулах, хоргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАТ		Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
НИЙТ ДҮН					2,400,000		

3.7 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас өгсөн саналын дагуух 1.0 га талбайд техникийн нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

№	Дүйцүүлэн хамгааллын стратеги	Гүйцэтгэх ажил	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Биотехникийн арга хэмжээ	Биотехникийн арга хэмжээ авч орон нутаг болон бусад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.	10,000,000	2024 он
НИЙТ = 10,000,000				

3.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн жилийн ажлын хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг агаар, ургамал, амьтан, хөрс, усан орчинд шинжлүүлж байхаар хугацаа давтамж зардлыг тооцсон.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
АГААРЫН ЧАНАР						
1.1	Уурхайн бүх төрлийн машин механизмд үзлэг оношилгоо засварыг тогтмол хийж байх	Төсөлд ашиглагдах машин механизм, дизель түлшнээс гарах утаа агаар орчныг бохирдуулж, хорт хий тархах	Уурхайд ашиглагдаж байгаа бүх машин техник, уурхайн дотоод замууд	Жилд 2 удаа	Нийт 100,000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1.2	Уурхайн замуудад усалгаа хийх замаар тоосжилтыг бууруулах	Салхи ихтэй үед их хэмжээгээр тоос шороо дэгдэх, машин механизмыг богино зайд олон эргэлтэйгээр ашиглахаас агаарт тоосжилт үүсэх				MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
ХӨРСНИЙ БОХИРДОЛ						
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Карьер, овоолго, замын орчимд	жилд 2 удаа	Нийт 40,000	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
						MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.2	Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, баталсан маршрутаар явуулж хэвшүүлэх, олон салаа зам гаргуулахгүй байх	Байнгын хөл хөдөлгөөнөөс байгууламжуудын ойр орчмын хөрсөн бүрхэвч доройтох элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэх	Уурхайн дотоод замууд	жилд 2 удаа	Нийт 100,000	
УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ						
3.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ		Төслийн талбайн худаг	Жилд 2 удаа	Нийт 100,000	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3.2	Саарал усны шинжилгээ	Саарал усыг зам талбайн усалгаанд ашиглах	Төслийн талбайд	ҮАТ	Нийт 300,000	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
УРГАМЛЫН АЙМАГ						

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төхөмийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
4.1	Уурхайн тосгоны талбайд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх бут сөөг тарих зүлэгжүүлэх	Уурхайн болон ажилчдын хотхон үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч талхагдах	Уурхайн тосгон	ҮАТ	500,000	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
АМЬТНЫ АЙМАГ						
5.1	Үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээрт махчин шувууны үүрнүүд байршуулах	Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах, орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Төсөл хэрэгжих талбайн ойролцоох бэлчээр нутагт	ҮАТ	300,000	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					НИЙТ = 1,440,000	

3.9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч “Премиумкөүл корпораци” ХХК жил бүр БОМТ - ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах Хамтарч	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн БОМТ , тайлан	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-